



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/40/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал

Утас:70350757

Цахим хаяг:azjargalb@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.08.25 № 78

танай _____-ны № _____-т

4-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.МИНЖ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол 4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал:

1. Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ байгуулаагүй 4,374.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 6.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно" гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар"-тай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Тайлант онд 99.3 мянган төгрөгийн өглөг, 618.5 мянган төгрөгийн авлага үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, тохилдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Сахилгын шийтгэлтэй ажилтанд 382.8 мянган төгрөгийн үр дүн, багш, нягтлан бодогч нарт 922.1 мянган төгрөгийн илүү цаг, тушаалаар халагдсан ажилчдад 2,216.7 мянган төгрөгийн цалин, 80.4 мянган төгрөгийн бусад нэмэгдэл урамшуулал, ажлын хөлс илүү бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3-д "илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Хүнсний материалын үлдэгдлээс ажилчдад 1,444.9 мянган төгрөгийн хүнсний материал олгосон мөн тус цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажилчдаас 578.6 мянган төгрөгийн хүнсний материалыг барилгын материалаар сольж ашигласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,343,111.24	112,274,405.36
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,630,000.00	3,115,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,630,000.00	3,115,000.00
3121	Төгрөг	3,630,000.00	3,115,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,630,000.00	3,115,000.00
33	АВЛАГА	-	618,502.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	139,340.00
335	Бусад авлага	-	479,162.12
3351	Байгууллагаас авах авлага	-	479,162.12
35	БАРАА МАТЕРИАЛ	75,713,111.24	108,540,903.24
351	Түүхий эд материал	69,498,481.24	96,812,421.24
35110	Тусгай зориулалттай материал	69,383,481.24	96,706,821.24
35130	Эм боох материал	115,000.00	105,600.00
354	Хангамжийн материал	6,214,630.00	11,728,482.00
35410	Бичиг хэргийн материал	697,230.00	2,755,100.00
35420	Аж ахуйн материал	2,076,200.00	4,022,232.00
35460	Хүнсний материал	3,441,200.00	4,951,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,872,170,248.15	1,839,705,593.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,872,170,248.15	1,839,705,593.78
392	Биет хөрөнгө	1,405,077,748.11	1,372,750,593.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,372,949,960.00	1,390,738,069.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(41,590,888.56)	(83,774,714.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,445,234.00	73,444,134.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,611,759.32)	(41,235,906.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,707,124.00	37,707,124.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,100,545.61)	(26,401,263.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,284,096.80	34,284,096.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,005,473.20)	(12,010,946.40)
393	Биет бус хөрөнгө	467,092,500.04	466,955,000.08
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(137,499.96)	(274,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	466,680,000.00	466,680,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,951,513,359.39	1,951,979,999.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	99,340.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	99,340.00
413	Өглөг	-	99,340.00
4136	Бусад өглөг	-	99,340.00

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41361	Байгууллагад төлөх өглөг	-	99,340.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,951,514,359.39	1,951,880,659.14
51	Засгийн газрын хувь оролцоо	1,951,514,359.39	1,951,880,659.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	970,446,846.00	970,446,846.00
51101	Өмч: - төрийн	970,446,846.00	970,446,846.00
512	Хуримтлагдсан үр дүн	(64,015,361.18)	(63,649,061.43)
51210	Өмнөх үеийн үр дүн	(64,015,361.18)	(64,015,361.18)
51220	Тайлант үеийн үр дүн	-	366,299.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,045,082,874.57	1,045,082,874.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,951,514,359.39	1,951,979,999.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	694,210,656.00	739,645,536.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,290,456.00	74,353,936.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,584,056.00	74,353,936.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,584,056.00	74,353,936.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	279,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,305,056.00	74,353,936.00
122	Тусламжийн орлого	27,706,400.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	27,706,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	636,920,200.00	665,291,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	531,237,400.00	612,955,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	531,237,400.00	612,955,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,464,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,464,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,218,600.00	52,336,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,218,600.00	52,336,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	724,069,572.22	736,482,576.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	724,069,572.22	736,482,576.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,584,089.67	725,460,463.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,492,728.00	462,454,493.37
210101	Үндсэн цалин	344,493,955.00	298,974,762.50
210102	Нэмэгдэл	42,475,029.00	124,327,269.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,397,076.90
210104	Урамшуулал	23,523,744.00	36,755,384.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,045,797.38	61,072,400.00
210201	Тэтгэврийн даатгал	53,045,797.38	54,264,991.91
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,708,152.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,359,801.61
210204	Ажилгүйдлийн даатгал	-	339,950.41

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,399,504.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,252,056.00	39,233,800.66
210301	Гэрэл, цахилгаан	4,918,868.00	3,134,440.02
210302	Түлш, халаалт	30,530,888.00	26,800,660.64
210303	Цэвэр, бохир ус	7,802,300.00	9,298,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,402,456.00	52,548,816.31
210401	Бичиг хэрэг	1,151,350.00	378,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534,522.00	156,686.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	67,284.00	9,996,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	649,300.00	42,017,200.00
2105	Нормативт зардал	114,988,332.00	45,949,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,450.00	197,800.00
210502	Хоол, хүнс	114,884,882.00	45,751,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,655,300.00	778,900.00
210604	Урсгал засвар	3,655,300.00	778,900.00
2107	Томилолт, зочны зардал	148,200.00	-
210702	Дотоод албан томилолт	148,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	770,000.00	1,563,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	485,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	770,000.00	1,078,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,829,220.29	61,859,163.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	2,032,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,043,100.00	1,574,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,486,120.29	58,251,663.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,485,482.55	11,022,112.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,247,735.17	201,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	38,752,935.17	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,494,800.00	201,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,244.00	10,821,112.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,244.00	10,821,112.54
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	208,503.38	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	208,503.38	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(29,858,916.22)	3,162,959.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,796,660.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	2,796,660.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,796,660.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(29,858,916.22)	366,299.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	664,905,600.00	675,339,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,985,400.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	279,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	279,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	279,000.00	-
122	Тусламжийн орлого	27,706,400.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	27,706,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	636,920,200.00	675,339,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	531,237,400.00	612,955,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	531,237,400.00	612,955,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,464,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,464,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,218,600.00	52,336,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,218,600.00	52,336,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	10,047,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	10,047,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	637,669,200.00	675,855,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,669,200.00	675,855,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,936,652.62	654,270,487.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,374,468.62	462,454,493.37
210101	Үндсэн цалин	344,442,479.62	299,914,102.50
210102	Нэмэгдэл	42,475,029.00	124,327,269.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,397,076.90
210104	Урамшуулал	23,456,960.00	35,816,044.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,066,300.00	61,072,400.00
210201	Тэтгэврийн даатгал	38,492,700.00	42,987,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,643,300.00	4,521,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,914,700.00	3,616,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	728,700.00	904,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,286,900.00	9,042,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,252,056.00	39,658,762.78
210301	Гэрэл, цахилгаан	4,918,868.00	3,559,402.14
210302	Түлш, халаалт	30,530,888.00	26,800,660.64
210303	Цэвэр, бохир ус	7,802,300.00	9,298,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,834,706.00	17,312,886.31

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	354,000.00	193,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534,522.00	156,686.31
210404	Ном, хэвлэл	-	64,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	67,284.00	10,119,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	878,900.00	6,778,700.00
2105	Нормативт зардал	120,842,672.00	65,319,245.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	218,450.00	316,200.00
210502	Хоол, хүнс	115,770,222.00	52,094,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,854,000.00	12,908,995.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,387,300.00	2,284,200.00
210604	Урсгал засвар	1,387,300.00	2,284,200.00
2107	Томилолт, зочны зардал	148,200.00	-
210702	Дотоод албан томилолт	148,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	770,000.00	1,437,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	359,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	770,000.00	1,078,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,260,950.00	4,731,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	612,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,960,950.00	4,118,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,732,547.38	21,584,612.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,494,800.00	10,763,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	10,047,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,494,800.00	716,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,244.00	10,821,112.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,244.00	10,821,112.54
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	208,503.38	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	208,503.38	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,236,400.00	(516,000.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,450,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,450,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,450,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	1,450,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,450,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	25,786,400.00	(516,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,630,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,786,400.00	3,115,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	970,446,846.00	1,045,082,874.57	(64,015,361.18)	1,951,514,359.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	970,446,846.00	1,045,082,874.57	(64,015,361.18)	1,951,514,359.39
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	970,446,846.00	1,045,082,874.57	(64,015,361.18)	1,951,514,359.39
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	970,446,846.00	1,045,082,874.57	(64,015,361.18)	1,951,514,359.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	970,446,846.00	1,045,082,874.57	(64,015,361.18)	1,951,514,359.39
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	366,299.75	366,299.75
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	970,446,846.00	1,045,082,874.57	(63,649,061.43)	1,951,880,659.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны	
		Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	638,881,452.6	679,168,900.0	654,470,487.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,431,452.6	679,168,900.0	654,470,487.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,936,652.6	678,968,900.0	654,270,487.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,374,468.6	462,458,100.0	462,454,493.4
210101	Үндсэн цалин	344,442,479.6	295,180,100.0	299,914,102.5
210102	Нэмэгдэл	42,475,029.0	128,242,200.0	124,327,269.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,360,000.0	2,397,076.9
210104	Урамшуулал	23,456,960.0	35,675,800.0	35,816,044.8
210105	Гэрээт ажлын хөлс			

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,066,300.0	61,072,400.0	61,072,400.0
210201	Тэтгэврийн даатгал	38,492,700.0	42,987,900.0	42,987,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,643,300.0	4,521,100.0	4,521,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,914,700.0	3,616,900.0	3,616,900.0
210204	Ажилгүйдлийн даатгал	728,700.0	904,200.0	904,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,286,900.0	9,042,300.0	9,042,300.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,252,056.0	50,052,400.0	39,658,762.8
210301	Гэрэл, цахилгаан	4,918,868.0	8,749,800.0	3,559,402.1
210302	Түлш, халаалт	30,530,888.0	31,641,100.0	26,800,660.6
210303	Цэвэр, бохир ус	7,802,300.0	9,661,500.0	9,298,700.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,834,706.0	17,330,100.0	17,312,886.3
210401	Бичиг хэрэг	354,000.0	193,400.0	193,400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534,522.0	156,700.0	156,686.3
210404	Ном, хэвлэл	-	121,000.0	64,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	67,284.0	10,080,400.0	10,119,900.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	878,900.0	6,778,600.0	6,778,700.0
2105	Нормативт зардал	120,842,672.0	79,236,500.0	65,319,245.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	218,450.0	316,200.0	316,200.0
210502	Хоол, хүнс	115,770,222.0	66,011,300.0	52,094,050.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,854,000.0	12,909,000.0	12,908,995.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,387,300.0	2,284,200.0	2,284,200.0
210604	Урсгал засвар	1,387,300.0	2,284,200.0	2,284,200.0
2107	Томилолт, зочны зардал	148,200.0	68,700.0	-
210702	Дотоод албан томилолт	148,200.0	68,700.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	770,000.0	1,735,400.0	1,437,400.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	359,200.0	359,200.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	770,000.0	1,376,200.0	1,078,200.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,260,950.0	4,731,100.0	4,731,100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.0	612,800.0	612,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,960,950.0	4,118,300.0	4,118,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,494,800.0	200,000.0	200,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,494,800.0	200,000.0	200,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,494,800.0	200,000.0	200,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,450,000.0	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,450,000.0	-	-
222001	Тоног төхөөрөмж	1,450,000.0	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	604,441,400.0	14,129,600.0	654,470,487.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	531,237,400.0	-	612,527,524.7

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	531,237,400.0	-	612,527,524.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,218,600.0	-	41,942,962.8
132001	Орон нутгийн төсвөөс	45,218,600.0	-	41,942,962.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	279,000.0	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	279,000.0	-	-
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	27,706,400.0	14,129,600.0	-
122001	Хандив тусламж /дотоод/	27,706,400.0	14,129,600.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	3,630,000.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,630,000.0	-	3,115,000.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд 4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ж.Минж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Б.Эрдэнэ, аудитор Б.Азжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чадварлаг багш ажилтан, эвсэг хамт олныг бүрдүүлж “Хүүхэд бүрийг хайрлан хүндэтгэж, эрүүл биетэй, ухаалаг, зөв төлөвшилтэй, зөв хүмүүжилтэй иргэн болгож хөгжүүлэн” үйлчилгээний шилдэг байгууллага бүрдүүлэхэд оршино.

4 дүгээр цэцэрлэг нь байгууллагын хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой хөгжлийг хангах, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах зорилтын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгон шинэчлэн баталж, мөрдүүлэх.
- Мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж бодлого, журам. Үүнд:

- Төрийн алба хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай /ЗГ-ын 472 дугаар тогтоол/
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Санхгийн сайдын тушаал, дүрэм журам
- БШУ-ны сайдын тушаал, дүрэм журам
- Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын тушаал, шийдвэрүүд
- Бусад хууль тогтоомж, дүрэм, журам

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

4 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 370,170.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,701.7 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд нийт орлогын дүн жилийн дүн тул 739,645.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,396.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,631.0	3,115.0	-516.0
Авлага		618.5	618.5
Урьдчилгаа			0
Бараа материал	75,713.1	108,540.9	32,827.8
Үндсэн хөрөнгө	1,872,170.1	1,839,705.6	-32,464.6
Нийт хөрөнгө	1,951,514.4	1,951,980.0	465.6
Өр төлбөр		99.3	99.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	970,446.8	970,446.8	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,951,514.4	1,951,980.0	465.6

Авлага дансны эцсийн үлдэгдэл 618.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цахилгааны төлбөрийг 479.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн мөн 139.3 мянган төгрөгийг НДШ, ХХОАТ-ыг буруу тооцоолсоноос үүссэн авлагууд байна.

Бараа материалын дансны энхний үлдэгдэл 75,713.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 108,540.9 мянган төгрөг болж 32,827.8 мянган төгрөгөөр өссөн нь шинээр өргөтгөл баригдаж анги хүүхдийн тоо өссөн бөгөөд дагаад нормын хувцас зөөлөн эдлэл, жижиг эд хогшил худалдан авсанаас шалтгаалжээ.

Тайлант онд өр төлбөр дансны үлдэгдэл 99.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НДШ-ийн өглөг байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 679,168.9 мянган төгрөгөөр боловсруулан төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд 2020 онд зарцуулах нийт зарлагыг 679,168.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 679,168.9 мянган төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр 654,470.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 24,698.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 679,168.9 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаандаа 654,470.5 мянган төгрөгийг зарцуулж 24,698.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

4 дүгээр цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 128 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаандаа оруулаагүй 2, хугацаа хоцроосон 13 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд нөхөн байршуулж 2020 оны дотоод аудитын нэгдсэн дүгнэлтээр 88.3% биелэлттэй дүгнэгдсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4 дүгээр цэцэрлэг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж, 1 төлбөрийн акт тавигдсан ба 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	760.0	1	760.0			
Албан шаардлага	1	13,682.0	1	13,682.0			
Зөвлөмж	1	0	1	0			
Нийт дүн	3	14,442.0	3	14,442.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19,817.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс 2,023.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3,602.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, санхүүгийн тайланд 9,100.0 мянган төгрөгийн алдааг залруулан, 5,092.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

4 дүгээр цэцэрлэг 2020 санхүүгийн тайланд 9,100.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд: Цалингийн зардлаас 985.1 мянган төгрөгийг мөнгөн дүнгээр ндш-ийн авлага руу 590.1 мянган төгрөгийн авлага, бараа материалын торуулгаас 4,025.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд, 3,500.0 мянган төгрөгийг цалин хооронд тус тус залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 5,625.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил илэрсэнээс 2,023.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3,602.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Үүнд: 1. Хүнсний материалын үлдэгдлээс ажилчдад 1,444.9 мянган төгрөгийн хүнсний материал олгосон. Барилгын өргөтгөл хийж буй байгууллага, иргэнээс 578.6 мянган төгрөгийн хүнсний материалыг барилгын материалаар сольж ашигласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2. Сахилагын шийтгэлтэй ажилтанд 382.8 мянган төгрөгийн үр дүн, багш, нягтлан бодогч нарт 922.1 мянган төгрөгийн илүү цаг, тушаалаар халагдсан ажилчдад 2,216.7 мянган төгрөгийн цалин, 80.4 мянган төгрөгийн бусад нэмэгдэл урамшуулал, ажлын хөлс илүү бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох

хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3-д "илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

1. Илрүүлэлт:

Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ байгуулаагүй 4,374.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 6.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

1.1. Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

1.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

2. Илрүүлэлт:

Тайлант онд 99.3 мянган төгрөгийн өглөг, 618.5 мянган төгрөгийн авлага үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

2.1. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдан, дотоод хяналтыг сайжруулж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.25-ны өдрийн 12 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТАЙЛАН БИЧСЭН:

Бэлтгэсэн: Аудитор	Б.Азжаргал	Огноо
Анхан шатанд хянасан: Аудитын менежер	Б.Эрдэнэ	Огноо
Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор	Ц.Нармандах	Огноо

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТАЙЛАН БИЧСЭН:

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Б.Азжаргал Огноо

Б.Эрдэнэ Огноо

Ц.Нармандах Огноо



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:20	Аудитын нэр:	4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.25			ОРА-2021/40/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		4 дүгээр цэцэрлэг	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хүнсний материалын үлдэгдлээс ажилчдад 1,444.9 мянган төгрөгийн хүнсний материал олгосон. Барилгын өргөтгөл хийж буй байгууллага, иргэнээс 578.6 мянган төгрөгийн хүнсний материалыг барилгын материалаар сольж ашигласан байна.	2,023.5	Албан шаардлага	Эрхлэгч нягтлан бодогч	Ж.Минж Б.Өсөхбаяр
2	Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн.	4,374.2	Зөвлөмж	Эрхлэгч нягтлан бодогч	Ж.Минж Б.Өсөхбаяр
3	Тайлант онд 99.3 мянган төгрөгийн өглөг, 618.5 мянган төгрөгийн авлага үүссэн байна	717.8	Зөвлөмж	Эрхлэгч нягтлан бодогч	Ж.Минж Б.Өсөхбаяр
4	Сахилагын шийтгэлтэй ажилтанд 382.8 мянган төгрөгийн үр дүн, багш, нягтлан бодогч нарт 922.1 мянган төгрөгийн илүү цаг, тушаалаар халагдсан ажилчдад 2,216.7 мянган төгрөгийн цалин, 80.4 мянган төгрөгийн бусад нэмэгдэл урамшуулал, ажлын хөлс илүү бодож олгосон байна.	3,602.0	Төлбөрийн акт	Эрхлэгч нягтлан бодогч	Ж.Минж Б.Өсөхбаяр
ДҮН		10,717.5			

Бэлтгэсэн: Аудитор

Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Ц.Нармандах Огноо



4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:20	Аудитын нэр:	4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.25			ОРА-2021/40/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	4 дүгээр цэцэрлэг		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хүнсний материалын үлдэгдлээс ажилчдад 1,444.9 мянган төгрөгийн хүнсний материал олгосон. Барилгын өргөтгөл хийж буй байгууллага, иргэнээс 578.6 мянган төгрөгийн хүнсний материалыг барилгын материалаар сольж ашигласан байна.	2,023.5	Албан шаардлага	Эрхлэгч нягтлан бодогч	Ж.Минж Б.Өсөхбаяр
2	Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн.	4,374.2	Зөвлөмж	Эрхлэгч нягтлан бодогч	Ж.Минж Б.Өсөхбаяр
3	Тайлант онд 99.3 мянган төгрөгийн өглөг, 618.5 мянган төгрөгийн авлага үүссэн байна	717.8	Зөвлөмж	Эрхлэгч нягтлан бодогч	Ж.Минж Б.Өсөхбаяр
4	Сахилагын шийтгэлтэй ажилтанд 382.8 мянган төгрөгийн үр дүн, багш, нягтлан бодогч нарт 922.1 мянган төгрөгийн илүү цаг, тушаалаар халагдсан ажилчдад 2,216.7 мянган төгрөгийн цалин, 80.4 мянган төгрөгийн бусад нэмэгдэл урамшуулал, ажлын хөлс илүү бодож олгосон байна.	3,602.0	Төлбөрийн акт	Эрхлэгч нягтлан бодогч	Ж.Минж Б.Өсөхбаяр
ДҮН		10,717.5			

Бэлтгэсэн: Аудитор  Б.Азжаргал Огноо
 Анхан шатанд хянасан: Аудитын менежер  Б.Эрдэнэ Огноо
 Хоёр дахь шатанд хянасан: Даога, тэргүүлэх аудитор  Ц.Нармандах Огноо

ОРА-2021/40/СТА-ТШЗ

17

СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ
ТЭМДЭГЛЭЛ

№ 05

2021 оны 02-р сарын 23-ны өдөр

Орхон аймаг

Захиргааны ерөнхий хуулийн дагуу 4-р цэцэрлэгийн нягтлан бодогчтой 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 цагт Нутгийн удирдлагын ордны 304 тоот албан ерөөнд биечлэн уулзах хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагыг төлөөлж:

Албан тушаал, нэр;

Албан тушаал, нэр;

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх:

Татгалзаж байгаа шалтгаан: _____

_____ гарын үсэг _____

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна. Гарын үсэг _____

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэл, мэдээллийг 4-р цэцэрлэгийн нягтлан бодогчид танилцуулав.

Асуулт, хариулт: Асуудлын бүртгэлээр танилцуулсан акт тогтоох, албан шаардлага өгөх алдаа зөрчилтэй асуудалтай холбоотой санал тайлбар байна уу?

Асуудлуудтай танилцсан холбогдох санал, тайлбар байхгүй, цаашид анхаарч ажиллах болно.

2020-02-р сарын 23-ны өдөр Нутгийн удирдлагын ордны 304 тоот албан ерөөнд биечлэн уулзах хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа. 2020-02-р сарын 23-ны өдөр Нутгийн удирдлагын ордны 304 тоот албан ерөөнд биечлэн уулзах хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа.


Сонсох ажиллагааг _____ 11:00 _____ цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл: Аудитор _____ /Б.Азжаргал/

Оролцогч: 4-р цэцэрлэгийн эрхлэгч _____ /Ж.Минж/

Нягтлан бодогч _____ /Б.Өсөхбаяр/





ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 92/92 О.П.А-2021/40/СТА ТШЗ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 4-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнсний материалын үлдэгдлээс ажилчдад 1,444.9 мянган төгрөгийн хүнсний материал олгосон. Мөн барилгын өргөтгөл хийж буй байгууллага, иргэнээс 578.6 мянган төгрөгийн хүнсний материалыг барилгын материалаар сольж ашигласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хүнсний материалын үлдэгдлээс ажилчдад 1,444.9 мянган төгрөгийн материал олгосон мөн 578.6 мянган төгрөгийн хүнсний материалаар барилгын

материалаар сольж ашигласан зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ж.Минж, нягтлан бодогч Б.Өсөхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... Б.АЗЖАРГАЛ



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 58/58 ОРА-2021/40/СТА-ТШЗ Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сахилгын шийтгэлтэй ажилтанд 382.8 мянган төгрөгийн үр дүн, багш, нягтлан бодогч нарт 922.1 мянган төгрөгийн илүү цаг, тушаалаар халагдсан ажилчдад 2,216.7 мянган төгрөгийн цалин, 80.4 мянган төгрөгийн бусад нэмэгдэл урамшуулал, ажлын хөлс илүү бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй", Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3-д "илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход

дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.2-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. 4 дүгээр цэцэрлэг нь илүү тооцож олгосон үр дүнгийн урамшуулал, илүү цаг, ажлын хөлс болох 3,602.0 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ж.Минж, нягтлан бодогч Б.Өсөхбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Б.АЗЖАРГАЛ

